



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 4/100

Мөрөн сум

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 88 дугаар тогтоол, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “УКД-2020/10”, 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн “ББКД-67-45/23”, “ББКД-67-46/23” дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж бий болсон 699,686,144 (Зургаан зуун ерэн есөн сая зургаан зуун наян зургаан мянга нэг зуун дөчин дөрөв) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгүүдийг эзэмших байгууллагыг хавсралтаар баталсугай.

2. Хөрөнгө эзэмших байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, “төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу үндсэн хөрөнгийн холбогдох дансанд бүртгэж, 2024 оны дөрөвдүгээр улирлын тайланд тусгах.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Одончимэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/00 дугаар захирамжийн хавсралт

а/ Орон нутгийн өмчид бүртгэх барилга байгууламж, нийтийн эзэмшлийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжээ ж/м ²	Тоо	Балансын анхны өртөг /төг/	Байгуулсан элэгдэл /төг/	Үлдэгдэл үнэ /төг/	Бүртгэх шалтгаан	Эзэмших байгууллага
1	Спортын заалны барилга	ш	1	200,000,000.00	0.00	200,000,000.00	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн "УКД-2023/10" дугаар дүгнэлт	Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль
2	Цэцүүх багийн төвийн барилга	ш	1	249,843,072.00	0.00	249,843,072.00	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн "ББКД-67-45/23" дугаар дүгнэлт	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар
3	Цагаан бургас багийн төвийн барилга	ш	1	249,843,072.00	0.00	249,843,072.00	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн "ББКД-67-46/23" дугаар дүгнэлт	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар
Нийт дүн				699,686,144.00	-	699,686,144.00		

ооо